

Д/д	Асуулт	Хариулт
1	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарснаас хойш ямар хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлэх вэ?	Компанийн тухай хууль 17.4.Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.
2	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэхэд санхүүгийн тайланд тусгах шаардлагатай юу?	Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам” 4.2.5.компанийн тухайд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн, хассан тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл;
3	Шинээр компани үүсгэн байгуулах баримт бичгийг ямар хугацаанд бүртгүүлэх ёстой вэ?	Компанийн тухай хууль 15.1.Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.
4	Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулахад тогтоолоос гадна хурлын тэмдэглэл заавал байх шаардлагатай юу?	Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам” 4.2.Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 4.2.2.үүсгэн байгуулагч болон эрх барих дээд байгууллагын хурлын тэмдэглэл, тогтоол /шийдвэр/;
5	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болох уу?	Компанийн тухай хууль 62.1.Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: 62.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
6	Үнэт цаасны үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захирал өөрчлөхөд санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэний дараа улсын бүртгэлд бүртгүүлэх үү?	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 62.1.Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь Хороо байна. 63.1.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 63.1.9.зохицуулалттай этгээдийн удирдах албан тушаалтанд нэр дэвшигчийг тохиромжтой этгээд мөн эсэхийг тогтоох, түүнд ажиллах зөвшөөрөл олгох, эсхүл тохиромжтой бус этгээдийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх;
7	Монгол улсад оршин суугч гадаадын иргэн болон харьяалалгүй хүн төрийн бус байгууллага байгуулж болох уу?	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 5.1.7-д “Харьяалалгүй хүн гэж” аль ч улсын харьяат бус хүнийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэ хуульд “байнга оршин суугч гадаадын иргэн” гэдэг ойлголтыг тодорхойлоогүй. Иймд гадаадын иргэн үүсгэн байгуулагчаар байж болохгүй бөгөөд харин удирдах зөвлөлийн гишүүн байж болно.

8	Төрийн бус байгууллага нь ашгийн төлөө хуулийн этгээдийн /компанийн/ хувьцаа эзэмшигч байж болох уу?	Төрийн бус байгууллага нь ашиг олох зорилгогүй. Төрийн бус байгууллагын тухай хууль.8.1.1-д дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан бол шүүхээр албадан татан буулгахаар заасан.
9	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өв залгамжлагчийг ямар хугацаанд бүртгүүлэх вэ?	Иргэний хууль.531.2-д хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа олгоно гэж заасан.
10	Хаалттай хувьцаат компанийг улсын бүртгэлд хэрхэн бүртгүүлэх вэ?	Хаалттай хувьцаат компанийн гаргасан хувьцаа нь зөвхөн хаалттай хүрээнд арилжаалагдана. Хаалттай хувьцаат компани нь:- Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх- Гаргасан хувьцаа нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдээгүй байх- Хаалттай хувьцаат компанийн хувьцаа нь зөвхөн худалдагч, худалдан авагч талуудын тохиролцсон гэрээний үндсэн дээр үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур арилжаалагдана.
11	Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэхэд эрх бүхий байгууллагад мэдэгдэх хуулийн хугацаа гэж байдаг уу?	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль11.3.Энэ хуулийн 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.27.5.Хуулийн этгээд энэ хуулийн 11.3-т заасан хугацаанд өөрийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол шүүгч, эсхүл эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
12	Хөдөө орон нутгийн харьяалалтай компанийн бүртгэлийг тухайн харьяаллаараа заавал бүртгүүлэх ёстой юу?	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам.1.3-д улсын бүртгэлийн байгууллага дараах харьяаллын дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэнэ.1.3.3.орон нутагт бүртгэгдэх хуулийн этгээдийг тухайн аймгийн Улсын бүртгэлийн нэгж бүртгэнэ.
13	Хязгаарлагдмалхариуцлагатай компани үүсгэн байгуулахад үүсгэн байгуулагчийн тооны дээд хязгаар нь хэд байх вэ?	Компанийн тухай хууль. 5.1.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас дээшгүй байна.

14	Нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанид өртэй бөгөөд өрөндөө хувьцаа тэнцүүлэн өгөхөөр харилцан тохиролцсон бол тухайн өөрчлөлтийг бүртгүүлж болох уу?	Компанийн тухай хууль.25.1.Компанийн хувьцаанаас бусад үнэт цаас болон өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ.25.6.Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхтэй байна.
15	Хуулийн этгээдийн тамга, тэмдэг гээгдүүлсэн тохиолдолд хаана хандах вэ?	Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”2.2.3.тамга, тэмдэг, баталгааны тэмдгийг үрэгдүүлсэн бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зарлуулсан баримт, торгуулийн хуудас эсхүл шийтгэвэр, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хүсэлт, түүний эрх барих дээд байгууллагын шийдвэр, иргэний хүсэлтийг үндэслэн өмнөх хяналтын дугаарыг хүчингүй болгож хяналтын дугаар олгоно.
16	Хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдсөн тохиолдолд тамга, тэмдгээ хэрхэн өөрчлөх вэ?	Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”2.2.4.гэмтээсэн, оноосон нэр, хэлбэр өөрчилсөн бол тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг дахин олгохдоо тамга, тэмдэг, баталгааны тэмдгийг хураан авч өмнөх хяналтын дугаарыг хүчингүй болгоно.
17	Хуулийн этгээдийн тамга, тэмдэг элэгдсэн, хуучирсан бол яаж солих вэ?	Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”2.2.4.гэмтээсэн, оноосон нэр, хэлбэр өөрчилсөн бол тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг дахин олгохдоо тамга, тэмдэг, баталгааны тэмдгийг хураан авч өмнөх хяналтын дугаарыг хүчингүй болгоно.
18	Төрийн бус байгууллагын нэрийг англи үгийг галиглаж авч болох уу?	Хууль зүйн сайдын 2015 оны А/41 дүгээр тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам”3.9.Төрийн бус байгууллагын нэрийг гадаад үг, товчилсон үсгээр баталгаажуулахгүй.
19	Нэг хүн өдөрт хэдэн хуулийн этгээдийн нэр авч болох вэ?	Хууль зүйн сайдын 2015 оны А/41 дүгээр тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам”2.4.Иргэн, хуулийн этгээд ажлын нэг өдөрт 3 хүртэл нэрийг баталгаажуулж болно.

20	Хуулийн этгээдийн бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түтгэлдүүлсэн хоригийг хэрхэн цуцлуулах вэ?	Тухайн хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөнд хориг тавиулах албан бичиг ирүүлсэн эрх бүхий байгууллагаас хориг цуцлах тухай албан бичгийг хуулийн этгээдийн бүртгэлийн газарт ирүүлнэ.
21	Хуулийн этгээдийн бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түтгэлдүүлсэн хориг тавьсан тохиолдолд хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулж болох уу?	Болохгүй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль.18.1.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:18.1.10.улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түтгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх;
22	Хуулийн этгээдийг татан буулгах баримт бичгийг бүртгэлийн байгууллагад хэн бүртгүүлэх эрхтэй вэ?	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль.16.1.Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг өргөдөл гаргах эрх бүхий дараах этгээдийн аль нэг нь гаргаж болно:16.1.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;16.1.2.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч;16.1.3.хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан;16.1.4.хуулийн этгээд татан буугдах тохиолдолд татан буулгах комиссын дарга;16.1.5.итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд.
23	Орон нутгийн харьяалалтай хуулийн этгээдийн тамга тэмдэгний хяналтын дугаарыг хаанаас авах вэ?	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам.1.3-д улсын бүртгэлийн байгууллага дараах харьяаллын дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэнэ.1.3.3.орон нутагт бүртгэгдэх хуулийн этгээдийг тухайн аймгийн Улсын бүртгэлийн нэгж бүртгэнэ.
24	Компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирлын хүсэлтээр тухайн хуулийн этгээдийн бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түтгэлзүүлсэн хориг тавьж болох уу?	Болохгүй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль. 18.1.10.улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түтгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх;
25	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудасныхүчинтэй хугацаа хэдэн хоног вэ?	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль14.3.Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

26	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй бол яах вэ?	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 14.3.Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана. 14.4.Хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гаргаагүй бол хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хүчингүй болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг энэ хуульд заасны дагуу дахин гаргаж болно. Дээрх хугацаанд өөр иргэн тус нэрийг баталгаажуулж авагүй бол дахин баталгаажуулж авч болно.
27	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг дахин хийлгэхэд хураамж төлөх үү?	Засгийн газрын 2010 оны “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 237 дугаар тогтоолын дагуу хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулахад 500 төгрөг төлнө.
28	Компани байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний доод хязгаар хэд вэ?	Компанийн тухай хууль. 30.4.Хуульд өөрөөр заагаагүй бол компанийг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар тавихгүй.
29	Хуулийн этгээдийг ямар хугацаанд татан буулгадаг вэ?	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль-24.2-т “Иргэний хуулийн 32.3-т заасны дагуу татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа уг хуулийн этгээдийг татан буулгаж дууссан тухай холбогдох улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ” гэж заасан тул хуулийн этгээдийг татан буулгасан тухай өдөр тутмын сонинд нийтлүүлж, нийтэд мэдэгдсэнээс хойш 2 сар өнгөрсний дараа улсын бүртгэлийн байгууллагад хандаж бүртгэлээ хийлгэх боломжтой.
30	Гадаадад хийгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тохиолдолд хэрхэн баталгаажуулах вэ?	Гадаадад хийгдэж байгаа тохиолдолд хувьцаа худалдах, худалдан авах, бэлэглэлийн болон эрх шилжүүлэх гэрээг элчин сайдын яам болон консулын газрын нотариатаар эсвэл апостилиар гэрчилгээгээр баталгаажуулах.